



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/610

Номгон

Г Хариуцлагатай уул уурхай сургалт  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/7 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хариуцлагатай уул уурхай сургалтыг Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Галуут, Заг, Өлзийт сумдын иргэдэд 2023 оны 11 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Хариуцлагатай уул уурхай сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, шаардагдах зардлын тооцоог гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Уул уурхайн салбарын хууль тогтоомж, орон нутагт баримталж буй бодлого, чиглэлийг иргэдэд сурталчилж, хариуцлагатай уул уурхайг бэхжүүлэхэд төр, аж ахуйн нэгж, иргэний хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлыг зохион байгуулахыг Ажлын хэсэг (Э.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4.Дээрх арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардал 2,212,600 (Хоёр сая хоёр зуун арван хоёр мянга зургаан зуу) төгрөгийг Техник, хяналтын зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642311669

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 1010 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



## УДИРДАМЖ

### Хариуцлагатай уул уурхай сургалт зохион байгуулах тухай

#### Зорилго

Төрөөс уул уурхайн салбарт баримталж буй бодлого, уул уурхайн салбарын хууль тогтоомжийн талаар иргэдэд сурталчилж, хариуцлагатай уул уурхайн салбарыг төлөвшүүлэхэд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

#### Зохион байгуулагч

Аймгийн Засаг даргын Тамгын газар

Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Цагдаагийн газар

#### Хамрах хүрээ

Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Галуут, Заг, Өлзийт сумдын иргэд

#### Хугацаа

- Өлзийт сум – 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 09:00 цагт
- Баян-Овоо сум – 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 15:00 цагт
- Бууцагаан сум - 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 09:00 цагт
- Бөмбөгөр сум - 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 15:00 цагт
- Заг сум - - 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 09:00 цагт
- Галуут сум - - 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 15:00 цагт

#### Сургалтын хөтөлбөр (Өлзийт сум)

| № | Зохион байгуулах арга хэмжээ   | Хугацаа     | Хариуцах байгууллага  |
|---|--|-------------|---|
| 1 | 2  | 3           | 4   |
| 1 | Оролцогчдын бүртгэл  | 8.30 – 9.00 | Сумын ЗДТГ  |
| 2 | Сургалтын нээлт  | 9.00 – 9.05 | Сумын Засаг дарга   |
| 3 |  | 9.05 - 9.10 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Э.Ганзориг                       |
| 4 | Эрдэс баялгийн салбараас эдийн засагт үзүүлэх нөлөөлөл ба төрийн бодлого | 9.10 – 9.30 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Б.Намуун |

| 1  | 2   | 3            | 4   |
|----|---|--------------|---|
| 5  | Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хандив, дэмжлэгээр аймагт хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил    | 9.30 – 9.40  | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Б.Намуун                       |
| 6  | Уул уурхай ба орон нутаг  | 9.40 – 10.00 | Сумын Засаг дарга   |
| 7  | Уул уурхайн салбарын хууль тогтоомж, түүний хэрэгжилт   | 10.00-10.20  | Геологи, уул уурхайн хяналтын Улсын байцаагч Ц.Болорчимэг   |
| 8  | Уул уурхайн салбар дахь байгаль орчны бодлого   | 10.20-10.40  | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн Б.Наранбаатар                              |
| 9  | Уул уурхайн салбарт гарч буй зөрчил, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ                           | 10.40-11.00  | Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, Цагдаагийн ахмад У.Амаржаргал |
| 10 | Хууль бус алт олборлолтыг зогсоож, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын танилцуулга | 11.00-11.20  | “Баянхонгор аймгийн хариуцлагатай бичил уурхайчдын байгууллагуудын нэгдсэн холбоо” ТББ              |
| 11 | Тухайн суманд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн танилцуулга      | 11.20-11.40  | Компаний төлөөлөл   |
| 12 | “Хариуцлагатай уул уурхай ба орон нутгийн хамтын ажиллагаа” хэлэлцүүлэг                       | 11.40-12.30  | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Э.Ганзориг   |
| 13 | Сургалтын хаалт   | 12.30-12.40  | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Э.Ганзориг   |

### Сургалтын хөтөлбөр (Баян-Овоо, Бөмбөгөр, Галуут сум)

| № | Зохион байгуулах арга хэмжээ   | Хугацаа     | Хариуцах байгууллага  |
|---|--|-------------|---|
| 1 | 2  | 3           | 4   |
| 1 | Оролцогчдын бүртгэл  | 14.30–15.00 | Сумын ЗДТГ  |
| 2 | Сургалтын нээлт  | 15.00–15.05 | Сумын Засаг дарга   |
| 3 |  | 15.05-15.10 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Э.Ганзориг                       |
| 4 | Эрдэс баялгийн салбараас эдийн засагт үзүүлэх нөлөөлөл ба төрийн бодлого                   | 15.10–15.30 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Б.Намуун |
| 5 | Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хандив, дэмжлэгээр аймагт хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил | 15.30–15.40 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Б.Намуун |
| 6 | Уул уурхай ба орон нутаг   | 15.40–16.00 | Сумын Засаг дарга   |

| 1  | 2   | 3           | 4   |
|----|---|-------------|---|
| 7  | Уул уурхайн салбарын хууль тогтоомж, түүний хэрэгжилт   | 16.00-16.20 | Геологи, уул уурхайн хяналтын Улсын байцаагч Ц.Болорчимэг   |
| 8  | Уул уурхайн салбар дахь байгаль орчны бодлого   | 16.20-16.40 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн Б.Наранбаатар                              |
| 9  | Уул уурхайн салбарт гарч буй зөрчил, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ                           | 16.40-17.00 | Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, Цагдаагийн ахмад У.Амаржаргал |
| 10 | Хууль бус алт олборлолтыг зогсоож, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын танилцуулга | 17.00-17.20 | "Баянхонгор аймгийн хариуцлагатай бичил уурхайчдын байгууллагуудын нэгдсэн холбоо" ТББ              |
| 11 | "Тухайн суманд уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн танилцуулга     | 17.20-17.40 | Компаний төлөөлөл   |
| 11 | "Хариуцлагатай уул уурхай ба орон нутгийн хамтын ажиллагаа" хэлэлцүүлэг                       | 17.40-18.20 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Э.Ганзориг   |
| 12 | Сургалтын хаалт   | 18.20-18.30 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Э.Ганзориг   |


**Сургалтын хөтөлбөр (Заг, Бууцагаан сүм)**

| № | Зохион байгуулах арга хэмжээ   | Хугацаа      | Хариуцах байгууллага   |
|---|--|--------------|--|
| 1 | 2  | 3            | 4  |
| 1 | Оролцогчдын бүртгэл  | 8.30-9.00    | Сумын ЗДТГ   |
| 2 |  | 9.00 - 9.05  | Сумын Засаг дарга  |
| 3 | Сургалтын нээлт  | 9.05 - 9.10  | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Э.Ганзориг                          |
| 4 | Эрдэс баялгийн салбараас эдийн засагт үзүүлэх нөлөөлөл ба төрийн бодлого                   | 9.10 - 9.30  | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Б.Намуун    |
| 5 | Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хандив, дэмжлэгээр аймагт хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил | 9.30 - 9.40  | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Б.Намуун    |
| 6 | Уул уурхайн салбарын хууль тогтоомж, түүний хэрэгжилт                                      | 9.40 - 10.00 | Геологи, уул уурхайн хяналтын Улсын байцаагч Ц.Болорчимэг                        |
| 7 | Уул уурхайн салбар дахь байгаль орчны бодлого  | 10.00-10.20  | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн Б.Наранбаатар           |
| 8 | Уул уурхайн салбарт гарч буй зөрчил, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ                        | 10.20-10.40  | Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, Цагдаагийн |

| 1  | 2   | 3           | 4  |
|----|---|-------------|--|
|    |   |             | ахмад У.Амаржаргал   |
| 9  | Хууль бус алт олборлолтыг зогсоож, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын танилцуулга | 10.40-11.00 | “Баянхонгор аймгийн хариуцлагатай бичил уурхайчдын байгууллагуудын нэгдсэн холбоо” ТББ |
| 10 | “Хариуцлагатай уул. уурхай ба орон нутгийн хамтын ажиллагаа” хэлэлцүүлэг                      | 11.00-11.50 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Э.Ганзориг                                |
| 11 | Сургалтын хаалт   | 11.50-12.00 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Э.Ганзориг                                |

oOo

Аймгийн Васал даргын Ажлын Оны 11 дүгээр  
сарын 17-ны өдрийн Ажлын дугаар захирамжийн  
хоёрдугаар хавсралт



## ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Ганзориг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Ц.Болорчимэг Хууль, эрх зүйн хэлтсийн Геологи, уул уурхайн хяналтын  
улсын байцаагч

Б.Наранбаатар Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах  
мэргэжилтэн


У.Амаржаргал Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан  
эрүүгийн ахлах мөрдөгч, Цагдаагийн ахмад

Нарийн бичгийн дарга

Б.Намуун Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн мэргэжилтэн

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дүгээр  
сарын \_\_\_\_\_-ны өдрийн \_\_\_\_\_ дугаар захирамжийн  
гуравдугаар хавсралт



ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙ СУРГАЛТЫН  
ЗАРДЛЫН ТООЦОО

| №    | Зардлын нэр                                | Тоо           | Нэгж үнэ | Нийт үнэ  |
|------|--|---------------|----------|-----------|
| 1    | Албан хаагчдын томилолт,<br>буудлын зардал | 5 хүн*3 хоног | 64000    | 960,000   |
| 2    | Шатахуун                                   | 800 км        | 2530     | 404800    |
| 3    | Шатахуун                                   | 300 км        | 4130     | 247800    |
| 4    | Ус   | 300           | 1500     | 450,000   |
| 5    | Бичиг хэргийн зардал                       | 1             | 150,000  | 150,000   |
| Нийт |  |               |          | 2,212,600 |

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_